

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2021.01.25

| ЗГҮАХ-т тусгагдсан зорилт   | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ   | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр   | Нийт хөрөнгийн хэмжээ, 2021-2024 (сая төгрөг) | Суурь түвшин | Хэрэгжүүлэх байгууллага                |                   |  | 2020 оны хэрэгжилт, үр дүн, хэрэгжилтийн хувь |
|---|---|--|------------------|---|---|--------------|--|-------------------|--|---|
|   |   |  |                  |   |   |              | Үндсэн                                 | Хамтрагч          | Оролцогч   |   |
| <b>ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>   |   |  |                  |   |   |              |  |                   |  |   |
| <b>3.2.Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.</b> |   |  |                  |   |   |              |  |                   |  |   |
| 3.2.7. Хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг ахиулан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.  | 5 | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг барина. | 2020-2024        | Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт (30% "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ өөрийн хөрөнгө, 70% гадаад/дотоод хөрөнгө оруулалт, зээл) | 1,628,400.0                                   | 0%           | УУХҮЯам, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, ТӨБЗГ | Холбогдох яамдууд | <p><b>ТӨҮЗХ.</b> "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь үйлдвэрлэсэн зэсийн баяжмалаа тасралтгүй ажиллагаатай хос SKS технологиор зэсийн баяжмал хайлуулан, боловсруулах металлурги-химийн үйлдвэр байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулахаар БНХАУ-ын ENFI болон NFC консорциумтай 2019 оны 9 сарын 25-ны өдөр 5/289-19 тоот гэрээ байгуулж, 2020 оны 9 дүгээр сард ТЭЗҮ-ийн эцсийн тайланг хүлээн авсан.</p> <p>УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлөөс шинжээч томилуулах, хэлэлцүүлэх хүсэлтийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2020 оны 10 сарын 12-ны өдрийн ТБ-120-11/7218 тоот албан бичгээр хүргүүлсэн. 2020 оны 11 сарын 2-ны өдөр УУХҮЯ-аас ТЭЗҮ-ийг Эрдэнэт үйлдвэрийн Техникийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргах, 2017 оны "Хүнд үйлдвэрийн салбарын техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба хүлээн авах журам"-д нийцүүлэн бэлтгэх чиглэл өгсөн.</p> <p>УУХҮЯ-аас өгсөн чиглэлийн дагуу Техникийн зөвлөл 2020 оны 11 сарын 3-ны өдөр хуралдаж, ТЭЗҮ-ийг хүлээн авах, Элементийн хүхэр үйлдвэрлэх технологийн "үйлдвэрлэлийн туршилт"-ын ажлыг эхлүүлэхийг дэмжих тухай 14/1 тоот шийдвэр гаргасан.</p> |   |

| ЗГҮАХ-т тусгагдсан зорилт  | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ   | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр  | Нийт хөрөнгийн хэмжээ, 2021-2024 (сая төгрөг) | Суурь түвшин | Хэрэгжүүлэх байгууллага                |                   |          | 2020 оны хэрэгжилт, үр дүн, хэрэгжилтийн хувь  |
|--|---|--|------------------|--|---|--------------|--|-------------------|----------|--|
|  |   |  |                  |  |   |              | Үндсэн                                 | Хамтрагч          | Оролцогч |  |
|  |   |  |                  |  |   |              |  |                   |          | <p>Үйлдвэрлэлийн туршилтын ажлыг хийж гүйцэтгэх, хамтран ажиллах гэрээ байгуулах Үнэлгээний хороо байгуулагдсан. China ENFI Engineering гэрээний нөхцөл, техникийн даалгаврыг боловсруулж байна. Төслийн хэрэгжилтийг хангах үүднээс ТӨБЗГ-ын 2020 оны 677 дугаар тогтоолоор батлагдсан "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодорхой үе шатны ажлуудыг хийж гүйцэтгэхээр тусгасан.</p> <p>ТУХАЙН ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ: 90%</p>  |
|  | 6 | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ҮТП байгуулах ажлын хүрээнд Исэлдсэн хүдрийг нуруулдан уусгах үйлдвэр байгуулна. | 2020-2022        | Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт 34% "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ өөрийн хөрөнгө, 66% гадаад/дотоод хөрөнгө оруулалт, зээл/ | 167,371.0                                     | 0%           | УУХҮЯам, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, ТӨБЗГ | Холбогдох яамдууд |          | <p><b>ТӨҮЗХ.</b> "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын 2019 оны 05 сарын 16-ны өдрийн А/401 тоот тушаалын 2-р хавсралтаар байгуулагдсан "SX/EW технологиор катодын зэс боловсруулах үйлдвэрийн төслийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулагдан, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.</p> <p>БНХАУ-ын BGRIMM институт гүйцэтгэгчээр сонгогдсон боловч COVID-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас Захиалагч ба Гүйцэтгэгч талууд ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь заалтын дагуу тендер хүчинтэй байх хугацаанд гэрээний нөхцөлийг харилцан тохиролцож, гэрээ байгуулж амжаагүй.</p> <p>Сонгон шалгаруулалтыг дахин зарлахаар ТӨБЗГ-ын 2020 оны 677 дугаар тогтоолоор батлагдсан "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаад байна.</p> <p>ТУХАЙН ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ: 0%</p> |
| 3.7.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ. |   |  |                  |  |   |              |  |                   |          |  |

| ЗГҮАХ-т тусгагдсан зорилт   | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ  | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ, 2021-2024 (сая төгрөг) | Суурь түвшин | Хэрэгжүүлэх байгууллага |   |                        | 2020 оны хэрэгжилт, үр дүн, хэрэгжилтийн хувь   |
|---|---|---|------------------|-----------|---|--------------|-------------------------|---|------------------------|---|
|   |   |   |                  |           |   |              | Үндсэн                  | Хамтрагч                                  | Оролцогч               |   |
| 3.7.8. Үндэсний орон сууцны нэгдсэн корпорац байгуулж, орон сууцжуулах хөтөлбөрийг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэ зохион байгуулалтаар өргөжүүлэн хэрэгжүүлнэ. | 1 | Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци байгуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, корпорацийг шинээр байгуулна. | 2020-2024        | -         | -   | -            | БХБЯам, ТӨБЗГ           | Аймаг, нийслэлийн ЗДТГ, СЯам, Монгол-банк | Олон улсын байгууллага | <p><b>ТӨУЗХ.</b> Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 172 дугаар тушаалаар Ажлын хэсгийг байгуулж, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Ажлын хэсгээс 2020.09.01-09.31-ны өдрүүдэд холбогдох баримт бичигт шалгалт хийж, гарсан санал, дүгнэлтийг Барилга, хот байгуулалтын яамны удирдлагын бүрэлдэхүүнд 2020.12.01-ний өдөр танилцуулж, Барилга, хот байгуулалтын сайдын Зөвлөлийн 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. Гарсан шийдвэрийг 2020.12.11-ний өдрийн 1/3981 тоот албан бичгээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлснийг судлан боловсруулж, хуралдаанаар хэлэлцүүлэн 2020 оны 683 дугаар тогтоолоор “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрэм болон үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулсан. Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 48 дугаар захирамжаар “Төрийн орон сууцны корпораци” ХХК, “Нийслэлийн орон сууцны корпораци” ОНӨХК-ийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар ахлуулан байгуулсан. Мөн Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 63, 64, 66 дугаар тушаалаар Ажлын дэд хэсгүүд байгуулагдан тодорхой чиглэлүүдээр ажиллаж байна. Ажлын хэсгээс хяналт шалгалтын дүн болон цаашид авах арга хэмжээний саналаа Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна. Засгийн газрын хуралдааны шийдвэрээс хамаарч Үндэсний орон сууцны корпораци байгуулах, түүний дүрэм, чиг үүргийг тодорхойлох зэрэг ажлууд хийгдэнэ.</p> <p>ТУХАЙН ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ: 30 %</p> |

| ЗГҮАХ-т тусгагдсан зорилт   | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ   | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр   | Нийт хөрөнгийн хэмжээ, 2021-2024 (сая төгрөг) | Суурь түвшин   | Хэрэгжүүлэх байгууллага                             |                  |   | 2020 оны хэрэгжилт, үр дүн, хэрэгжилтийн хувь   |
|---|---|--|------------------|-------------|---|--|---|------------------|---|---|
|   |   |  |                  |             |   |  | Үндсэн  | Хамтрагч         | Оролцогч  |   |
| <b>ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО</b>  |   |  |                  |             |   |  |   |                  |   |   |
| <b>4.1.“Цахим Монгол”- төрийн шуурхай үйлчилгээ. Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.</b> |   |  |                  |             |   |  |   |                  |   |   |
| 4.1.4. Төрийн үйлчилгээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ.  | 1 | Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг төрийн үйлчилгээний e-Mongolia платформд холбоно.  | 2020-2024        | Улсын төсөв | 7,360.0                                       | Иргэн, хуулийн этгээдэд Төрийн үйлчилгээний e-mongolia.mn системээр дамжуулан 181 үйлчилгээг хүргэж байна. | ТӨБЗГ /Манайх тусгаар гүй, манай асуудал биш байна/ | ХЗДХЯ, СЯ, ХХМТГ | Төрийн болон орон нутгийн өмчит 6000 хуулийн этгээд | <p><b>МТА.</b> Энэ арга хэмжээг ТӨБЗГ-аас хариуцахаар санал тусгаагүй бөгөөд энэ чиг үүрэг тус байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэгт хамаарахгүй.</p> <p><b>ТЭМДЭГЛЭЛ:</b> Цаашид энэ арга хэмжээг ТӨБЗГ-ын хариуцах үүргээс хасах саналтай байна.</p> <p><b>Хэрэгжилтийн дүнгээс хасч тооцов.</b></p>   |
|   | 5 | Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож (программ хангамж, техник хангамж, 2 ширхэг сервер), нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн мэдээллийн сан, төрийн бусад байгууллагын мэдээллийн системтэй холбоно. | 2021-2024        | Улсын төсөв | 1,200.0                                       | Программын болон техник хангамжийг сайжруулах шаардлагатай.  | ТӨБЗГ   | ХЗДХЯ, СЯ, ХХМТГ | Төрийн болон орон нутгийн өмчит 6000 хуулийн этгээд | <p><b>МТА, ТӨБАХ.</b> Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн мэдээллийн нэгдсэн системийг бий болгож хэрэгжүүлэх "Мэдээлэл, технологийн алба"-ыг шинээр байгуулан ажиллаж байна. Тухайн асуудлыг хэрэгжүүлэхэд чиглэсэн стратеги, тактикийн хувилбарыг боловсруулж, байгууллагын 2021-2024 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх зорилт тавиад байна.</p> <p>Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй, 2021 оноос тооцно.</p> |

| ЗГҮАХ-т тусгагдсан зорилт   | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ  | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ, 2021-2024 (сая төгрөг) | Суурь түвшин   | Хэрэгжүүлэх байгууллага |          |                             | 2020 оны хэрэгжилт, үр дүн, хэрэгжилтийн хувь   |
|---|---|---|------------------|-----------|---|--|-------------------------|----------|-----------------------------|---|
|   |   |   |                  |           |   |  | Үндсэн                  | Хамтрагч | Оролцогч                    |   |
| <b>4.2.Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.</b> |   |   |                  |           |   |  |                         |          |                             |   |
| 4.2.4. Төрийн болон нийтийн өмчийн үр ашигтай, зохистой ашиглалт, хэрэглээг дэмжиж, удирдлага, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх замаар төрийн өмч үнэгүйдэх асуудлыг таслан зогсооно.                   | 1 | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чадавхийг бэхжүүлж, төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, нөхцөлөөр хангана. | 2021-2024        | -         |   | Эрх зүйн орчин сул, бүтэц, орон тоо, төсөв хангалтгүй. | ТӨБЗГ                   | ЗГХЭГ    | Аймаг, нийслэлийн ИТХ, ЗДТГ | <p><b>Бүх хэлтэс, алба.</b> Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 144 дүгээр тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын орон тооны хязгаарыг өөрчлөн тогтоосноор Ерөнхий сайдын 2020 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 79 дүгээр захирамжаар Засгийн газрын тус агентлагийн үйл ажиллагааны стратеги, бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орж, чадавхийг нэмэгдүүлэх арга хэмжээ авсан нь зорилт, арга хэмжээг хэрэгжих эхний алхам болж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байгаа бөгөөд уг хуулийн төсөлд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхой болгох асуудал шийдвэрлэгдэнэ.</p> <p>Хэрэгжилтийг тооцож эхлэх хугацаа болоогүй, 2021 оноос тооцно.</p> |

| ЗГҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ   | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр   | Нийт хөрөнгийн хэмжээ, 2021-2024 (сая төгрөг) | Суурь түвшин      | Хэрэгжүүлэх байгууллага |          |          | 2020 оны хэрэгжилт, үр дүн, хэрэгжилтийн хувь  |
|---------------------------|---|--|------------------|-------------|---|-------------------|-------------------------|----------|----------|--|
|                           |   |  |                  |             |   |                   | Үндсэн                  | Хамтрагч | Оролцогч |  |
|                           | 2 | Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, захиран зарцуулалтад хяналт шалгалт хийж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулна. | 2020-2024        | Улсын төсөв | 196.0   | 19 хуулийн этгээд | ТӨБЗГ                   | СЯ       |          | <p><b>ТӨХШХ.</b> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66.4 дэх заалтын дагуу 2020 онд хэрэгжүүлэх хяналт шалгалтын төлөвлөгөөг Сангийн яамтай зөвшилцөн баталж, хэрэгжүүлэв. 2020 онд төлөвлөгөөт 35, гүйцэтгэлийн 10 болон төлөвлөгөөт бус шалгалтыг тухай бүр хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс төлөвлөгөөт 19, гүйцэтгэлийн 10, төлөвлөгөөт бус 7 хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна. Коронавируст халдварын цар цахлын улмаас орон нутагт байршилтай төрийн өмчит хуулийн этгээдэд хийхээр төлөвлөсөн 16 хяналт шалгалт хэрэгжих боломжгүй, цуцлагдсан байна.</p> <p>1.2020 онд хийсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнгээр 21,290.74 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд нийт зөрчлийн 22.57% нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, 49.15% нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, 19.22% нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 9.06% нь Засгийн газар болон ТӨБЗГ-ын тогтоол шийдвэрийг зөрчсөн зөрчил дутагдал тус тус эзэлж байна. Шалгалтын тайлангийн нийт дүнгээр цаашид авч хэрэгжүүлэх 84 арга хэмжээ, холбогдон гарсан тогтоол шийдвэрийн 104 арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг, даалгаврыг холбогдох хуулийн этгээдэд өгсөн байна.</p> <p>2.Шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний хэрэгжилтэд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийхэд зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч байгаа болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал сайжирсан дүнтэй байна.</p> |

| ЗГҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ  | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр   | Нийт хөрөнгийн хэмжээ, 2021-2024 (сая төгрөг) | Суурь түвшин     | Хэрэгжүүлэх байгууллага |          |          | 2020 оны хэрэгжилт, үр дүн, хэрэгжилтийн хувь   |
|---------------------------|---|---|------------------|-------------|---|------------------|-------------------------|----------|----------|---|
|                           |   |   |                  |             |   |                  | Үндсэн                  | Хамтрагч | Оролцогч |   |
|                           |   |   |                  |             |   |                  |                         |          |          | <p>2020 онд шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр тэдгээр хуулийн этгээдээс 2018-2019 онд улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн түрээсийн орлогын 34.97 сая, ногдол ашгийн 247.37 сая төгрөгийг улсын төсөвт, дээд байгууллагыг санхүүжүүлсний улмаас компанид учирсан 2.8 сая төгрөгийн хохирлыг байгууллагад нь татан төвлөрүүлж, гүйцэтгэх удирдлагын буруутай үйл ажиллагааны улмаас хуулийн этгээдэд учирсан 27.0 сая төгрөгийг нөхөн төлүүлэх асуудалд Санхүүгийн хяналт шалгалтын Улсын ахлах байцаагчийн акт тогтоосон зэрэг үр дүн гарсан байна.</p> <p>ТУХАЙН ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ: 90%</p>   |
|                           | 3 | Төсөвт байгууллагын эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын байдалд хяналт шалгалт хийж, төрийн өмчийн үр ашгийг нэмэгдүүлнэ. | 2020-2024        | Улсын төсөв | 75.0  | 7 хуулийн этгээд | ТӨБЗГ                   | СЯ       |          | <p><b>ТӨХШХ.</b> 2020 онд 7 төсөвт байгууллагын эд хөрөнгийн эзэмшилт, захиран зарцуулалтын байдалд төлөвлөгөөт системийн хяналт шалгалтыг хэрэгжүүлсэн дүнгээр 370.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд төсвийн хөрөнгөөр бий болж байгаа эд хөрөнгөд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас хуулийн дагуу бүртгэх, олж авах зөвшөөрөл авдаггүй, төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу ажилладаггүй байдал нийтлэг тогтоогдсон. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулсан шалгалтын дүнгээр цаашид авч хэрэгжүүлэх 33 арга хэмжээ, тогтоол шийдвэрийн 36 арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг даалгаврыг тус тус өгсөн байна. Мөн цар тахал болон томилолтын төсөв татагдсан нөхцөл байдлын улмаас хөдөө орон нутаг дахь төрийн өмчит 3 эмнэлэгт хийхээр төлөвлөсөн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх боломжгүй болсон.</p> <p>ТУХАЙН ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ: 90%</p> |

| ЗГҮАХ-т тусгагдсан зорилт  | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ   | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр   | Нийт хөрөнгийн хэмжээ, 2021-2024 (сая төгрөг) | Суурь түвшин                                | Хэрэгжүүлэх байгууллага |          |          | 2020 оны хэрэгжилт, үр дүн, хэрэгжилтийн хувь   |
|--|---|--|------------------|-------------|---|---|-------------------------|----------|----------|---|
|  |   |  |                  |             |   |   | Үндсэн                  | Хамтрагч | Оролцогч |   |
| <b>4.4. Хараат бус бие даасан шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэл. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хууль ёсыг бэхжүүлнэ.</b>               |   |  |                  |             |   |   |                         |          |          |   |
| 4.4.10. Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд | 1 | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. | 2020-2023        | Улсын төсөв | 20.0  | Хуулийн төслийг боловсруулсан байна. /40.0/ | ХЗДХЯ                   | ТӨБЗГ    | ЗГХЭГ    | <p><b>ХЭЗХ. Хамтран хэрэгжүүлэгчээр үүрэг хүлээсэн.</b> Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн А/174 дүгээр тушаалаар байгуулагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэлтсийн дарга нар ажиллаж байна. 2020 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайдтай Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга, хэлтсийн дарга нар уулзаж, хуулийн үзэл баримтлалын төслын талаар танилцуулсан. ХЗДХЯ-аас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн үзэл баримтлалын төслийг зөвшөөрсөн тул ЗГХЭГ-т хүргүүлэхэд бэлэн болоод байна.</p> <p>Мөн ТӨБЗГ нь хуулийн төсөл боловсруулахад МУИС-ийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн багш, УИХ-ын зөвлөхүүдийг татан оролцуулах арга хэмжээ авч, ТӨБЗГ-т дэд ажлын хэсгийг байгуулан хамтран ажиллаж байна. Түүнчлэн, Төрийн болон орон нутгийн өмчийн талаар мэдээлэл, судалгаа танилцуулгыг бэлтгэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт хүргүүлэв.</p> <p>ТУХАЙН ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ: 90%</p> |



| ЗГҮАХ-т тусгагдсан зорилт       | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ  | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ, 2021-2024 (сая төгрөг) | Суурь түвшин                                       | Хэрэгжүүлэх байгууллага |          |   | 2020 оны хэрэгжилт, үр дүн, хэрэгжилтийн хувь   |
|---------------------------------|---|---|------------------|-----------|---|--|-------------------------|----------|---|---|
|                                 |   |   |                  |           |   |  | Үндсэн                  | Хамтрагч | Оролцогч  |   |
| нийцүүлэн боловсронгуй болгоно. | 2 | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагалдан гарах дүрэм, журмыг боловсруулж, батална.        | 2021-2023        | -         |   | Зарим дүрэм, журам батлах эрх хуулиар олгогдоогүй. | ТӨБЗГ                   | ХЗДХЯ    | Аймаг, нийслэлийн ЗДТГ  | <p><b>ХЭЗХ.</b> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх хуулийн жагсаалтад тусган баталсан байсан нь хойшлогдсон байна. Хуулийн төсөл батлагдсаны дараа дагалдан гарах дүрэм, журмыг боловсруулах, батлуулах ажлууд хийгдэнэ.</p> <p>Хэрэгжилтийг тооцох хугацаа 2021 оноос эхэлнэ.</p>                                |
|                                 | 3 | Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд олон улсын нийтлэг шаардлагад нийцсэн засаглалын зарчмыг нэвтрүүлнэ. | 2021-2024        |           |   | Компанийн засаглалын дундаж үнэлгээ - 53.9 хувь    | ТӨБЗГ                   | ЗГХЭГ    | Удирдлагын Академи, Компанийн засаглалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ | <p><b>ТӨҮЗХ.</b> "Компанийн засаглалын хөгжлийн төв" ТББ-тай хамтран 2021 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 8 хуулийн этгээдэд компанийн засаглалын үнэлгээг хийхээр төлөвлөж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн тухай хуулийн төсөлд компанийн засаглалын талаар холбогдох саналыг тусгах арга хэмжээ авсан болно.</p> <p>Хэрэгжилтийг тооцох хугацаа 2021 оноос эхэлнэ.</p> |

| ЗГҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ   | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр   | Нийт хөрөнгийн хэмжээ, 2021-2024 (сая төгрөг) | Суурь түвшин  | Хэрэгжүүлэх байгууллага |                                  |   | 2020 оны хэрэгжилт, үр дүн, хэрэгжилтийн хувь   |
|---------------------------|---|--|------------------|-------------|---|---|-------------------------|----------------------------------|---|---|
|                           |   |  |                  |             |   |   | Үндсэн                  | Хамтрагч                         | Оролцогч  |   |
|                           | 4 | Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийг сайжруулах, үр өгөөжийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна. | 2022-2024        | -           |   | Хуулийн этгээдэд урт болон дунд хугацааны бизнес /хөгжлийн/ төлөвлөгөө байхгүй.       | ТӨБЗГ                   | ЗГХЭГ                            | -   | <p><b>ТӨУЗХ.</b> Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 46 хуулийн этгээдийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн баталсан. Тэдгээр төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниуд нийт дүнгээр, 2021 онд 7.7 их наяд төгрөгийн орлого олж, 6.7 их наяд төгрөгийн зардал гарган 927.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөсөн ба мөн онд төсвийн төлбөр 1.6 их наяд төгрөг, ногдол ашигт 184.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр 2021 оны үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.</p> <p>Хэрэгжилтийг тооцох хугацаа 2022 оноос эхэлнэ.</p>                         |
|                           | 5 | Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулж, төрийн өмчид бүртгэлээр хяналт тавина.  | 2021-2024        | Улсын төсөв | 425.0   | 2016 оны улсын нэгдсэн тооллогын дүнгийн мөрөөр авах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн. | ТӨБЗГ                   | 21 аймгийн ОНӨГ, Нийслэлийн ӨАУГ | Төрийн болон орон нутгийн өмчит 6200 хуулийн этгээд | <p><b>ТӨБАХ.</b> Төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ээлжит ажлыг 2021 онд зохион байгуулахаар Засгийн газрын 2020 оны 46 дугаар тогтоолоор хойшлуулсан. Үзлэг, тооллогын ажлын бэлтгэлийг хангах зорилгоор холбогдох маягт, зааварт нэмэлт өөрчлөлт оруулах зөвшөөрлийг Үндэсний статистикийн хорооны зөвшөөрлийг үндэслэн ТӨБЗГ-ын 2020 оны 323 дугаар тогтоолоор баталсан. Улсын үзлэг, тооллогын төлөвлөгөө, хуваарь гаргаж, зохион байгуулалтын ажлын бэлтгэлийг хангав. Шаардлагатай төсвийн асуудлаар чиглэл авах тухай хүсэлт бүхий албан бичгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Хэрэгжилтийг тооцох хугацаа 2021 оноос эхэлнэ.</p> |

| ЗГҮАХ-т тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ, 2021-2024 (сая төгрөг) | Суурь түвшин | Хэрэгжүүлэх байгууллага |          |          | 2020 оны хэрэгжилт, үр дүн, хэрэгжилтийн хувь |
|---------------------------|---|----------------------------------|------------------|-----------|---|--------------|-------------------------|----------|----------|---|
|                           |   |                                  |                  |           |   |              | Үндсэн                  | Хамтрагч | Оролцогч |   |

### ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (ЗГҮАХХАХТ)-нд тусгагдсан арга хэмжээ (заалт) бүрийн хэрэгжилт, үр дүнгээр тайлагнав. Нийт 2 бүлэг бодлогын хүрээний 5 тэргүүлэх зорилтод хамаарах 5 зорилтыг хэрэгжүүлэх 12 арга хэмжээг ТӨБЗГ--т хяналтад авч, хэрэгжилтийг тайлагнав. Эдгээр 12 арга хэмжээнээс 11 арга хэмжээг шууд (үндсэн хэрэгжүүлэгч) хариуцан, 1 арга хэмжээг нь бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн.

Үнэлгээний дүнгийн товч танилцуулга (2020 оны жилийн эцсийн дүнгээр):

ЗГҮАХХАХТ-нд тусгагдсан арга хэмжээ (заалт)-ний тоо – 12; Үүнээс:

90%-ийн хэрэгжилттэй - 4 арга хэмжээ;

30%-ийн хэрэгжилттэй - 1 арга хэмжээ;

0 %-ийн хэрэгжилттэй - 1 арга хэмжээ;

Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа буюу “Үнэлэх боломжгүй” – 6 арга хэмжээ, үүнээс (2021 оноос хэрэгжиж эхэлнэ).

ЗГҮАХХАХТ-ний тухайн жилийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ, хувь – "Эрчимжүүлэх шаардлагатай" буюу 65.0 %.

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Хянасан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

Нэгтгэн боловсруулсан:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ  
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ